

УЛСЫН НЭРЭНД НЭМЭРЛЭХ НЬ

(Өлгөц)

Б.Лааган

Монгол нутагт ээлжлэн товойн гарч байсан эртний улсууд 1100 оны эхээр дуусгавар болсон түүхтэй. Тэр улсуудын суурин дээр жижиг ханлиг улс, бие даасан аймаг, аймгийн холбоонд XIII зууны эх хүртэл оршин тогтносон. Тэдгээрийг Чингис тэргүүтэй хааны алтан ургийнхан удирдан зохион байгуулж нэгэн “дээвэр” дор багтаасан билээ. Тэр нь одоогоос 800 жилийн өмнө буюу 1206 онд бүрэлдсэн шинэ хэлбэр, маягийн улс байв. Энэ улсыг судлаачид, болоод ном зохиолд янз бүрээр нэрлэн бичиж ирлээ. Бие даасан, хууль цааз бүхий төр улсын хувьд “тогтсон” нэртэй байх нь зүйн хэрэг. Тэр нэр нь баримтаар баталгаажсан, зөв оносон, тухайн улсын “байдал”-ыг бүрэн илэрхийлсэн тусгасан байх нь зүйд нийцэх бөлгөө. Сурвалж судлалд 1206 оны нэгдмэл улсын нэрийн талаар дурьдсан нь ховор.

Академич Ч.Далай, Ш.Бира, Ж.Болдбаатар нарын бүтээлүүдэд 1206 онд бүрэлдсэн шинэ улсыг “Их Монгол” улс хэмээн бараг анх удаа нэрлэсэн байгаа. Ч.Далай 1994 онд хэвлүүлсэн “Их Монгол улс” 1206-1260 гэсэн бүтээлдээ “Их Монгол” гэсэн нэрийг оноон өгсөн төдийгүй зайлшгүй ингэж хэрлэгдэхийн учрыг олон баримтанд тулгуурлан тодорхойлсон байгаа.

Ш.Бира Ардын хувьсгалын 75 жилийн ойд зориулан хийсэн ШУА-ийн бүх гишүүдийн эрдэм шинжилгээний их чуулганд 1996 онд тавьсан илтгэлдээ: “Орчин цагийн улс төр судлалын ухаанд улсын тухай ойлголтыг элдвээр тодорхойлдог боловч, аливаа улс нь бүрэн утгаараа хүн ам, газар нутаг, төр болон бүрэн эрхт байдал хэмээх дөрвөн үндэсэн зүйлээс зайлшгүй бүрэлдэх ёстой хэмээн үздэг байна. Энэ шалгуураар авч үзвэл Чингис хааны 1206 онд байгуулсан улс нь улсын тухай орчин цагийн ухагдахууны болзлыг хангасан Их Монгол улс гэсэн дүгнэлт хийсэн байна.

Ж.Болдбаатар: Их, дээд сургуулийн багш, оюутан нарт зориулсан “Монгол улсын түүх” гэсэн бүтээлд: Тэмүжин 1185-1206 оны хооронд их, бага гучин хоёр удаагийн тулалдаан хийж байж, монгол угсааны нийт наян нэгэн аймгийг араасаа дагуулан “хагацсан” улсаа хамтатгаж, бутарсан улсаа бүртгэх “их зүйл бүтээсэн билээ. Энэ үе бол Их Монгол улс байгуулагдах явц дахь нэг ёсны шилжилтийн үе болжээ гээд ийнхүү Их Монгол хэмээх улс төв Азийн гээжнээ байгуулагдах, мандан

бадарсан юм” (Монгол улсын түүх. УБ. 1999. 65-66) гэж жинтэй дүгнэлт хийж, шинэ тутам байгуулагдсан улсын нэрийг тодорхойлон өгсөн байна.

Нэгэн зүйл: Хэрлэнгийн хөдөө аралд болсон Их хуралдай Монгол туургатныг нэгтгээд удирдагчийг нь тодруулах гэж урьд өмнө болоогүй учралуудтай тохиолдсон. Тэдгээрийн нэгэн баримтаас дурьдахад хааны алтан ургийн ойрын төрөл болох тодруулбал, их ор суух магадлал өндөртэй ах дүү Тэмүжин Хасар нар үеэл бөгөөд авга болох Алтан, Хучир, Сачабэх зэрэг ид эрч хүчин дээрээ яваа ахан дүүс хаан ширээний төлөө хүч түрэн өрсөлдсөн байдаг. Тэдний дотроос 1189 онд Далай хан буюу Чингис гэсэн алдарт цол хүртсэн Тэмүжин ялалт байгуулаад уул цолоо өргөн бататгаад хаан суудалд суусан. Тэрбээр хаан сэнтий дээрээс анхныхаа үгийг айлтгажээ. Тэр би хөх тэнгэрийн өршөөлөөр, тэнгэр газрын эвээлээр их улсаа жолоодох боллоо гэсэн. Чингисийн энэ үг 1206 онд эмхлэгдсэн улсын нэрийг тодруулан хэлжээ гэхээс аргагүй санагдана.

Нэгэн зүйл: Далай хааны удирдлага дахь Монгол улсын төрийн тамгыг хүнпэтгэн сүр сүлд болгон хэрэглэсэн. Тамга нь монгол хүний ур, ухаанаар цагаан хаш чулуугаар хийгдсэн. Түүн дээрээ “Мөнх тэнгэр хүчин дор Их Монгол улсын Далай хааны зарлигийг ил булга иргэн дор хүргэвээс биширтүгэй, аюутугай” гэсэн бичээс сийлсэн байгаа. Энэ нь төрийн тамга бөгөөд түүнийг Хасбуу тамга гэж тодотгосон бололтой. Алтваа нэгэн улс орон хийгээд байгууллага газрыг баталгаажуулах зүйл нь түүний тамга. Ингэж ойлговол Хасбуу тамга тухайн үеийн улсын нэрийг илтгэх мэт.

Нэгэн зүйл: 1206 онд байгуулагдсан төрт улсын гол хууль нь “Их засаг” хууль. Энэ хуулийг оноон хэрлэхдээ ч Чингис хааныхаа айлдварыг бодолцон тухайн улсынхаа нэртэй холбон “Их” гэсэн нэрийг оруулсан байхыг үгүйсгэхгүй.

Энэ бүхнийг цухасхан дурьдахын учир нь Монгол улсын шинжлэх ухааны академиас боловсруулан 2003 онд хэвлүүлсэн Монгол улсын бүрэн хэмжээний түүхэнд дурьдан буй үеийн улсын ч олон Монгол аймаг улсыг нэгтгэн захирсан Монголын тулгар төр Нэгдсэн Монгол улс байгуулагдсаныг албан ёсоор тунхаглан зарлажээ. (Монгол улсын түүх. Дэд боть. 96 дахь тал) гээд “Монголын нэгдсэн төв улс” (мөн 104 талд) гэжээ. Дээр дурьдсан “Их Монгол улс” гэсэн нэр, санаа энэхүү түүхэнд бичигдсэнгүй. Сүүлийн жилүүдэд Монголын түүхийн судалгаа нь нэг загвараас зайлж, бичлэг арга хэлбэрт нь ч шинэлэг хандлага нэвтэрч байгаа билээ.

Энэ бүхнийг бодолцсон ч “феодалын нэгдсэн улс”, “Монголын тулгар төрт улс”, “Нэгдсэн улс” гэхчлэнгээр нэрлэх нь учир дутагдалтай санагдана. Ер нь Монгол нутаг дээр 1206 онд эмхлэн зохион байгуулагдсан шинэ улсыг Чингис хаан “Их Монгол улс” гэж нэрлэсэн юм биш үү.

Түүхт ойг тэмдэглэх талаар төр, засгаас гаргаж буй зарлиг шийдвэрт төдийгүй ойн урилга, зарлагад ч хүртэл “Их Монгол улс” гэсэн нэрийг бататган оруулах нь зохимжтой болов уу?